



БАЛТАНГЭРЭЛ

ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн процессийн эрх зүйн тэнхмийн эрхлэгч, докторант, дэд хурандаа

ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО, ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ-ШИНЭЧЛЭЛ

“Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны шинэчлэл” сэдэвт Олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцогч та бүхэнд энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Монгол улсын шийдвэр гүйцэтгэх байгууллага, тэдгээрийн үндсэн чиг үүргийг гүйцэтгэгч субъект болох шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын шинэчлэлийн талаар авч үзэхийн өмнө өнөөгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдалд дүн шинжилгээ хийн, тулгамдаж буй асуудлаа тодорхойлон, шийдвэрлэх арга замыг нээн илрүүлэх нь чухал юм.

Илтгэлийг үндсэн 2 хэсэгт хуваан авч үзэх ба эхний хэсэгт:

1. Шийдвэр гүйцэтгэх байгууллага, түүний тогтолцоо, чиг үүрэг-шинэчлэл

2. Шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдал-шинэчлэл гэсэн хэлбэртэй байна.

Шийдвэр гүйцэтгэх байгууллага, түүний тогтолцоо, чиг үүрэг-шинэчлэл:

Иргэд хооронд буюу банк болон банкны бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршооноос барьцаагүй зээл, барьцаат зээлийн төлбөр, гэм хорын хохирол төлбөр, хүүхдийн тэтгэлэгийн

төлбөр, оршуулгын зардлын төлбөр, малын хулгайн төлбөр, ажилгүй байсан хугацааны цалин болон ажилд эргүүлэн тогтоох, хорихоос өөр төрлийн ял /торгууль, албадан ажил хийлгэх ял, эд хөрөнгө хураах ял, тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрх хасах ял/ зэрэг нийгмийн харилцаанд гарсан мөнгө, эд хөрөнгөтэй холбоотой асуудлаар зохих журмаар шүүхээс гаргасан шийдвэрийг гүйцэтгэх нь хууль сахиулах байгууллага тэр дотроо Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үндсэн үүрэг билээ.

2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар шийдвэр гүйцэтгэлийн салбарын шинэчлэлийг гүнзгийрүүлэх, зах зээл хөгжсөн орны жишигт ойртуулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг аль болох өөрийгөө санхүүжүүлэх зарчмыг тогтоох, төрийн албан хаагч-шийдвэр гүйцэтгэх байгууллагыг ажилтны хариуцлага, сахилгыг дээшлүүлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг шуурхай үр ашигтай, зардлаа нөхөх боломжтой болж, шүүхийн шийдвэрийн биелэлтийг бодитой дээшлүүлж, хүний зөрчигдсөн эрхийг бүрэн утгаар сэргээх, өр барагдуулах системийг бий болгох зэрэг зарчмуудыг тогтоосон билээ.

Монгол Улсад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх улмаар иргэний чиглэлийн шүүхээс гаргасан шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллага, албан тушаалтан үүсч хөгжиж ирсэн түүхэн уламжлалыг авч үзвэл:

Засгийн газрын гишүүдийн 1926 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 15 дугаар хурал БНМАУ-ын Бага хурлын тэргүүлэгчдийн 21 дүгээр хурлаар баталсан

“БНМАУ-ын аливаа шүүх таслах газруудыг шинэчлэн байгуулах тухай” дүрэм батлагдсан өдрийг тус улсад Ардын шүүх байгуулагдсан өдөр гэж тогтсон байна. Улмаар 1926 оны эцэс 1927 оны эхний хагас жил хүртэлх хугацаанд 71 хошуунд ардын шүүхийг сонгон байгуулсан байна. Тэгэхдээ 10 хүртэл сутай хошуунд шүүхийн түшмэлийн үүргийг хошууны даргад хавсаргаж, 100-гаас дээш сумтай хошуунд шүүхийн түшмэлийг тусгайлан сонгож байжээ. Тухайн үед шүүхийн тогтоол гүйцэтгэлийн ажиллагааг шүүхийн түшмэл ба хошууны дарга хариуцаж байсан талаар ямар нэгэн баримтанд дурдаагүй ба 1965 он гэхэд хэсгийн шүүхүүдэд тогтоол гүйцэтгэлийн асуудлыг шүүгч хариуцдаг байсан байгаагаас харахад Ардын шүүх байгуулагдсан анхны жилүүдэд тогтоол гүйцэтгэлийн үйл ажиллагааг хошууны шүүхийн түшмэл болон хошууны дарга явуулдаг байсан бололтой гэж үздэг.

БНМАУ-ын Бага хурлын тэргүүлэгчдийн 1930 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 7 дугаар хурлаас засан хүмүүжүүлэх байгууллагыг шүүхээс тусгаарлаж 1931 онд хошуудын шүүхийг татан буулгаж, хөдөөд ангийн /хэсгийн/ 36 шүүх, аймгийн 13 шүүх, цэргийн 3 шүүхтэй Улаанбаатар хотын шүүхийг шинээр байгуулжээ.

БНМАУ-ын бага хурлын тэргүүлэгчдийн 1949 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 9 дүгээр зарлигаар БНМАУ-ын шүүхийн зохион байгуулалтын хуулийг баталж, ардын хэсгийн шүүхүүдийг сонгон байгуулсан. Энэ үеэс улсын хэмжээний тогтоол гүйцэтгэлийн ажлыг БНМАУ-ын шүүх явдлын яам хариуцдаг байсан бөгөөд тус яамны зохион зааварлах хэлтэст тогтоол гүйцэтгэлийн асуудал хариуцсан ямар нэг

байцаагч ажиллаж байсан гэж тэмдэглэсэн байдаг.

БНМАУ-ын Их хурлын тэргүүлэгчдийн 1959 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн зарилгаар БНМАУ-ын Шүүх явдлын яамыг татан буулгаж түүний үүргийг БНМАУ-ын Дээд шүүхэд шилжүүлэх үед тогтоол гүйцэтгэлийн асуудлыг дээд шүүх хариуцдаг болжээ.

1962 оноос БНМАУ-ын Дээд шүүхэд шүүхүүдийн зохион байгуулалтын өдөр тутмын ажлыг /шүүхүүдийн тогтоол гүйцэтгэл/ удирдах шүүхийн байгууллагын хэлтэс шинээр байгуулагдан ажилласан.

1965 онд Улаанбаатар хотын хэсгийн шүүхийг татан буулгаж түүний районуудын шүүхийг байгуулсан ба шүүхүүд гаргасан тогтоол болон шийдвэрээ биелүүлэх үйл ажиллагаа явуулдаг байсан тухайн үед улсын дээд шүүх, цэргийн шүүх, аймаг хотын шүүхэд тогтоол гүйцэтгэгч тус бүр нэг хүнтэй, хэсгийн шүүхүүдэд тогтоол гүйцэтгэлийн асуудлыг шүүгч, нарийн бичгийн дарга нар хариуцдаг байсан.

Улсын Дээд шүүхэд дээд шүүхийн тэргүүлэгчид болон шүүхийн байгууллагын хэлтэс байгуулагдан тогтоол гүйцэтгэгчийн албыг бэхжүүлэх, гүйцэтгэгчийн орон тоог нэмэгдүүлэх, цалин хангамжийг дээшлүүлэх, мэргэжлийн боловсон хүчнээр хангах, эрх үүргийг нь өндөржүүлэх талаар хөгжүүлэх дэс дараалсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна.

1985 онд БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 237 дугаар тогтоолоор шүүхийн тогтоол гүйцэтгэх журмын тухай заавар”-ыг баталж, энэ зааврыг ажилд хэрэгжүүлэхтэй холбогдуулан бусад яам, тусгай газартай хамтран 12 заавар, журам гаргаж хэрэгжүүлсэн байна. Дээрх заавар нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн үйл

ажиллагааг хэрхэн явуулах гүйцэтгэгч нарыг ажилд томилох, ажлаас чөлөөлөх, гүйцэтгэлийн ажилд хөтлөгдөх маягтууд болон тогтоол гүйцэтгэлийн хяналт шалгалтын асуудал зэргийг томъёолсон анхны бие даасан эрх зүйн акт байна.

БНМАУ-ын Бага хурлын 1990 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 23 дугаар тогтоолоор Дээд шүүхийн эрхэлж байсан шүүхийг зохион байгуулалтын удирдах ажлыг тогтоол гүйцэтгэлийн асуудлын хамт хууль зүйн яаманд шилжүүлж орон нутаг энэ чиг үүргийг аймгийн захиргааны хууль зүйн хэлтэс эрхлэн гүйцэтгэж байв.

Хууль зүйн яаманд шүүхийн зохион байгуулалтыг удирдах газар гүйцэтгэлийн албыг байгуулан ажиллуулжээ. Энэ үед БНМАУ-ын Их хурлын 1993 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 15 дугаар тогтоолоор шүүхийн ерөнхий зөвлөл бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлснээс хойш нэг сарын хугацаанд багтаан хууль зүйн яамны шүүхийн зохион байгуулалтыг удирдах газар, тогтоол гүйцэтгэх албыг төв, орон нутагт ажиллаж буй холбогдох ажилтны орон тоо, төсвийн хөрөнгийн хамт шүүхэд шилжүүлсэн байна.

1996 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн Монгол улсын Шүүхийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль болон 1996 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн Шүүхийн Шийдвэр Биелүүлэх Тухай хуулиар шүүхийн тогтоол гүйцэтгэлийн асуудал хорих байгууллагыг удирдах газартай нэгдэн шүүхийн шийдвэр биелүүлэх газарт шилжсэн. Ийнхүү 1990-1996 онд шийдвэр гүйцэтгэлийн харьяалал 3 удаа өөрчлөгдсөн байна.

1996 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн Монгол Улсын Шүүхийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль

болон 1996 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль, Засгийн газрын 1996 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн тогтоолоор Улсын Дээд шүүхийн Тамгын газрын шийдвэр гүйцэтгэлийн хянан байцаах хэлтэс, Хорих байгууллагуудыг удирдах газрыг нэгтгэн Засгийн газрын хэрэгжүүлэг агентлаг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болгон өөрчилсөн юм.

Өнөөгийн байдлаар Монгол улсын иргэн, захиргааны хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний бүтцийн нэгжийн талаар авч үзвэл:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад нь улсын хэмжээний эрүүгийн ял /хорих/, иргэн, захиргааны хэргийн шүүхийн шийдвэр, албадлагын шинж чанартай шүүхийн зарим төрлийн шийдвэрийг гүйцэтгэж байна.

2. Дээрхи олон төрлийн шийдвэрийг хуулиар нэгэн адил зарчмаар хэрэгжиж байна.

3. Шийдвэр гүйцэтгэгч нь зөвхөн иргэн, захиргааны шийдвэрийг гүйцэтгэхээс гадна хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааг давхар гүйцэтгэж байна.

Гадаад улс орнуудын хувьд авч үзвэл:

Тухайлбал: Холбооны Бүгд Найрамдах Герман улс, Япон, Америкийн нэгдсэн улс, Англи зэрэг улсад шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн тогтолцооны талаар дурдахад.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг нутаг дэвсгэрийн шүүхэд харьяалагддаг шийдвэр гүйцэтгэгч хэрэгжүүлдэг ба шийдвэр гүйцэтгэгчийн харьяалагддаг нутаг дэвсгэрийн шүүхийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага гэж тодорхойлсон байдаг байна.

Шийдвэр гүйцэтгэгч нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг нутаг дэвсгэрийн шүүхийн хяналтын дор гүйцэтгэж, төлбөр төлөгчийн эд хөрөнгөнд халдах эрхийг хэрэгжүүлдэг байна.

Жишээлбэл Холбооны Бүгд Найрамдах Герман улс, Япон, Америкийн Нэгдсэн улс, Англи гэх мэт дэлхийн ихэнхи улс орнуудын өр барагуулах байгууллага нь шүүхийн харьяандаа үйл ажиллагаагаа явуулж байна.

Эндээс дүгнэж үзэхэд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагын бүтэц тогтолцооны шинэчлэлтийн талаар доорхи дүгнэлтэд хүрч болох юм.

1.Монгол улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөрт зааснаар “шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг ялгамжтай явуулна” гэсэн заалтын хүрээнд зарчим, үйл ажиллагааны бүтцийг өөрчлөх

2.Гадаад орны шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцооны нийтлэг байдал нь:

-Шүүхийн харьяанд байх

-Тусдаа төрийн байгууллага байх

-Хувийн байгууллага гүйцэтгэх

-Нэгдсэн /бүх төрлийн/ шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага байх гэсэн хэлбэрүүд байгааг Монгол улсад хэрэгжих байдлыг судлах

Шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдал-шинэчлэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан түүний эрх зүйн баталгаа нь доорх байдлаар зохицуулагдсан байдаг.

1. Шийдвэр гүйцэтгэгчээр эрх зүйн боловсролтой, шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад орж тэнцсэн, Монгол

улсын иргэн байхаар хуульчилсан нь эрх зүйн чиглэлээр сургалт явуулдаг их, дээд сургуулиудад шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр хичээл бага цагаар ордог, зарим сургуулиудад заадаггүй зэрэг нь шийдвэр гүйцэтгэгчийн амь нас, эрүүл мэндэд халдах болзошгүй тохиолдолд хүндрэл учруулна.

Иймээс Хууль сахиулагч-шийдвэр гүйцэтгэгчийг тусгайлан хууль сахиулахын их сургуульд бэлдэх, шийдвэр гүйцэтгэгчийн нийгэм, улс төр, эдийн засгийн баталгааг хангах чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг шинээр боловсруулах шаардлага амьдралаас урган гарч байгаа юм.

2.Шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх албыг бий болгох, урамшууллын системийг уян хатан болгох нь тухайн ажиллагааны үр дүнг дээшлүүлэх чухал хөшүүрэг болох юм.